



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 05 сарын 07 өдөр

Дугаар Д/18

Мөрөн сум

Комисс томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар, "ХААНБАГАНА"-ХХК-ний хооронд байгуулсан ХЭАОНӨГ/20230101002/ дугаартай ажил гүйцэтгэх гэрээгээр Орон нутгийн Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалттай "Ахмадын байрны засвар, тоног төхөөрөмж" нийлүүлэх явцад байнгын хяналт хийх, хүлээн авах эрх бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Г.Хишигбаатар-

Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн

Гишүүдэд: Э.Балчиндорж-

"Цагаан толгой" багийн Засаг дарга.

Г.Мөнхцэцэг-

Аж ахуй нярав

2. "ХААНБАГАНА"-ХХК-ны хийж байгаа "Ахмадын байрны засвар, тоног төхөөрөмж" -д техникийн тодорхойлолтод заасан стандартыг хэрэгжүүлж ажиллаж буй эсэхэд байнгын хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдалыг арилгуулж ажиллахыг комиссын нийт гишүүдэд үүрэг болгосугай.

3. "ХААНБАГАНА" ХХК-аас "Ахмадын байрны засвар, тоног төхөөрөмж" -ийг хүлээн авахдаа гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтыг үндэслэн акт үйлдэн хүлээн авч үндсэн хөрөнгөнд бүртгэж авч ажиллахыг комиссын дарга(Г.Хишигбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.НАМЖИЛНОРОВ.

C:\My Documents\ ТУШААЛ .doc

234002018